МОНГОЛ УЛС
**ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2019 оны 05 сарын 20 өдөр Дугаар А/197 Мандалговь

Үнэлгээний хорооны гишүүнээс чөлөөлж,
нөхөн томилох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1, 47.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Үнэлгээний хорооны гишүүн Т.Дорждамба нь "Дундговь–Ус" ОНӨҮГазарт нярваар ажилладаг бөгөөд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжих "БНСУ-ын Гуяан хотын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж байгаа Аз жаргалын төгөл" 100 га ойн зурвасын усалгааг цэвэр усны төвлөрсөн системд холбох ажил"-д "Дундговь–Ус" ОНӨҮГазар тус тендерт оролцож байгаа тул ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал бий болсон тул гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны гишүүнээс чөлөөлсүгэй.

Хоёр. Гуяан хотын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж байгаа Аз жаргалын төгөл" 100 га ойн зурвасын усалгааг цэвэр усны төвлөрсөн системд холбох ажил"-ын үнэлгээний хорооны гишүүнээр Д.Мөнхцоожийг нөхөн томилсугай.

Гурав.Тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу шуурхай зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Г.Самданцоодол)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА О.БАТ-ЭРДЭНЭ

408190516